



ТЕНДЕРТ ОРОЛЦОГЧДОД

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГЖҮҮЛЭГЧ АГЕНТЛАГ  
**ТӨРИЙН ХУДАЛДАН АВАХ  
АЖИЛЛАГААНЫ ГАЗАР**

Б корпус, Засгийн газрын IX байр,  
Энхтайваны өргөн чөлөө 16, Баянзүрх дүүрэг,  
Улаанбаатар хот, 13381  
Утас/Факс: (976-51) 26 00 62  
Цахим шуудан: info@spa.gov.mn  
Цахим хуудас: www.spa.gov.mn

2024.06.25 № А-1/2766  
танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

**Тодруулга хүргүүлэх тухай**

Тус газраас зарласан ЗТХЯ/20240101035 дугаартай XV.1.1.40 “Аймгийн төвийн хатуу хучилттай авто замын үргэлжлэл, 15.6 км /Говь-Алтай, Есөнбулаг сум/” төсөл, арга хэмжээний тендер шалгаруулалтад оролцохыг сонирхогч этгээдээс ирүүлсэн тодруулгад захиалагч Зам, тээврийн хөгжлийн яамнаас ирүүлсэн тодруулгын хариуг хавсралтаар хүргүүлж байна.

Дээрх тодруулга ирсэнтэй холбоотой тендерийн баримт бичигт дараах өөрчлөлтийг оруулж байна. Үүнд :

- ТШЗ 26.1. “Огноо: 2024 оны 6 дугаар сарын 05-ны өдөр. Цаг: 11 цаг 00 минут” гэснийг “Огноо: 2024 оны 7 дугаар сарын 03-ны өдөр. Цаг: 11 цаг 00 минут” гэж;
- ТШЗ 26.2. “Огноо: 2024 оны 6 дугаар сарын 05-ны өдөр. Цаг: 11 цаг 10 минут” гэснийг “Огноо: 2024 оны 7 дугаар сарын 03-ны өдөр. Цаг: 11 цаг 10 минут” гэж тус тус өөрчлөв.

Төрийн худалдан авах ажиллагааны цахим систем /www.tender.gov.mn/-д дээрх өөрчлөлтийг тусгасан тендерийн баримт бичиг болон ТЭЗҮ хэсэгт ажлын зураг төслийг шинэчлэн байршуулсан болно.

Хавсралт: 1. хуудастай.

ДАРГА



Ц.БАТЗУЛ

1324027451



ТӨРИЙН ХУДАЛДАН АВАХ  
АЖИЛЛАГААНЫ ГАЗАРТ

МОНГОЛ УЛСЫН  
ЗАМ, ТЭЭВРИЙН ХӨГЖЛИЙН ЯАМ

Засгийн газрын XIII байр, Чингисийн өргөн чөлөө 11,  
Сүхбаатар дүүрэг, Улаанбаатар хот, 14251  
Утас: (976-51) 26 31 79. Факс: (976-11) 31 23 15,  
Цахим шуудан: info@mrtд.gov.mn,  
Цахим хуудас: www.mrtд.gov.mn

2024.06.07 № 03/2570

танай 2024.05.24 -ны № А-1/2159 -т

Тодруулга хүргүүлэх тухай

Танай байгууллагын 2024 оны 05 дугаар сарын 24-ний өдрийн А-1/2159 дугаар албан бичгээр ирүүлсэн Монгол Улсын 2024 оны төсвийн тухай хуулийн 2 дугаар хавсралт "Монгол улсын төсвийн хөрөнгөөр 2024 онд санхүүжүүлэх хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээ, барилга байгууламжийн жагсаалт"-ын XV.1.1.40-д туссан "Аймгийн төвийн хатуу хучилттай авто замын үргэлжлэл, 15.6 км (Говь-Алтай, Есөнбулаг сум)" төсөл, арга хэмжээний тендерт оролцохыг сонирхогч этгээдээс ирүүлсэн асуулгад дараах тодруулгыг хүргүүлж байна.

Дээрх төсөл, арга хэмжээний зураг төслийг Кадсүрвэй" ХХК 2021 онд боловсруулан "Зам, тээврийн хөгжлийн төв" ТӨҮГ-аар 2022 онд 09/2022 дугаартай магадлалын ерөнхий дүгнэлт гаргуулан баталгаажуулж Говь-Алтай аймгийн Засаг Даргын Тамгын газарт хүлээлгэн өгсөн байна.

Иймд "Зам, тээврийн хөгжлийн төв" ТӨҮГ-ын 2022 оны 01 дүгээр сарын 28-ны өдрийн 09/2022 дугаар магадлалын ерөнхий дүгнэлтээр баталгаажсан "Кадсүрвэй" ХХК-ийн боловсруулсан зургийн дугаар КС-50/21 Говь-Алтай аймаг, Алтай хотын 26.3 км авто зам, замын байгууламжийн ажлын зураг төсөл (Багц-2)-ыг мөрдөж ажиллана уу.

"Кадсүрвэй" ХХК-ийн боловсруулсан зургийн дугаар КС-50/21 Говь-Алтай аймаг, Алтай хотын 26.3 км авто зам, замын байгууламжийн ажлын зураг төсөл (Багц-2)-ыг PDF файлаар хавсаргав.

Хавсралт .6. хуудастай.

ТӨРИЙН НАРИЙН БИЧГИЙН  
ДАРГА

С.БАТБОЛД

